



**ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2018 оны 03 сарын 28 өдөр

Дугаар 25.

Есөнбулаг сум

Журам батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.3-ын "Н", 20 дугаар зүйлийн 20.1.14 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Орон нутгийн өмчит байгууллагуудын "Өмч хамгаалах байнгын зөвлөлийн ажиллах журам"-ыг хавсралтаар баталсугай.
2. "Өмч хамгаалах байнгын зөвлөлийн ажиллах журам"-ыг үйл ажиллагаандаа мөрдөж, хэрэгжилтийг хангахыг орон нутгийн өмчит хуулийн этгээдийн удирдлагууд, Орон нутгийн өмчийн газар /З.Мөнхнасан/-т, журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга /С.Гансэлэм/-д тус тус үүрэг болгосугай.
3. Уг журам батлагдсантай холбогдуулан аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2002 оны 56 дугаар тогтоолыг хүчингүй болгосугай.

ДАРГА

Т.ГАНЗОРИГ



0000036

ОРОН НУТГИЙН ӨМЧИТ ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ӨМЧ ХАМГААЛАХ БАЙНГЫН ЗӨВЛӨЛИЙН АЖИЛЛАХ ЖУРАМ

Нэг. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Өмч хамгаалах зөвлөл болон салбар зөвлөл нь үйл ажиллагаагаа хууль тогтоомж, журмын хүрээнд, өмчийн харилцааны талаар олгосон эрх хэмжээний дагуу явуулж хэрэгжүүлсэн ажлын дүнг өмч хамгаалах салбар зөвлөл нь түүнийг байгуулсан этгээд болон түүний өмч хамгаалах байнгын зөвлөлд, өмч хамгаалах байнгын зөвлөл нь түүнийг байгуулсан эрх бүхий этгээд болон аймгийн Орон нутгийн өмчийн газарт жилд нэгээс доошгүй удаа тайлагнана.

1.2. Аймгийн Орон нутгийн өмчийн газраас өмч хамгаалах зөвлөл болон салбар зөвлөлийн ажилтай танилцаж мэргэжил, арга зүйн дэмжлэг туслалцаа үзүүлнэ.

1.3. Данснаас хасах тухай Өмч хамгаалах байнгын зөвлөлийн дүгнэлт гарсан эд хөрөнгийн шийдвэр гарч хангагдах хүртэл уг эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг тухайн байгууллагын удирдлага хариуцна.

1.4. Данснаас хасах тухай Өмч хамгаалах байнгын зөвлөлийн дүгнэлт гарсан эд хөрөнгийн шийдвэр гараагүй, эсвэл шийдвэр нь хангагдаагүй хугацаанд уг эд хөрөнгийн бүрэн бүтэн байдал алдагдвал түүнээс учирсан хохирол, хариуцлагыг байгууллагын дарга /захирал, эрхлэгч/ хүлээнэ.

Хоёр. ӨМЧ ХАМГААЛАХ БАЙНГЫН ЗӨВЛӨЛИЙН ЭРХ, ҮҮРЭГ

2.1. Өмч хамгаалах байнгын зөвлөлийн эрх.

2.1.1. Өмч хөрөнгийн тооллогоор маргаантай, дутагдуулсан болон илүүдэлтэй ашиглалтгүй байгаа болон цаашид ашиглах боломжгүй болсон хөрөнгийн шалтгааныг тогтоож дүгнэлт гарган байгууллагын удирдлагад танилцуулах

2.1.2. Өмч хөрөнгийн асуудлаар хяналт шалгалт хийлгэхээр эрх бүхий байгууллагуудад санал тавьж шийдвэрлүүлэх

2.1.3. Үр бүтээлтэй ажиллаж буй зөвлөлийн гишүүдийг урамшуулан шагнуулах талаар эрх бүхий байгууллага, удирдлагад уламжлан шийдвэрлүүлэх.

2.2. Өмч хамгаалах байнгын зөвлөлийн үүрэг.

2.2.1. Өмчийн харилцаатай холбогдон гарсан хууль тогтоомж, журам, зааврыг олон нийтэд сурталчлах, тухайн жилд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг боловсруулан зөвлөлийн хурлаар /эрх бүхий байгууллагын удирдлага/-аар батлуулан мөрдөж ажиллах.

2.2.2. Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн өмч хөрөнгийн хадгалалт хамгаалалт, бүртгэл, тооллого, тооцоо бодолт, ашиглалт, засвар, үйлчилгээний чанар байдалд байнгын хяналт тавих.

2.2.3. Байгууллагын эзэмшилд байгаа илүүдэлтэй болон ашиглалтгүй, элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн осол гэмтлийн улмаас болон ашиглалтын шаардлага хангахгүй болсон үндсэн хөрөнгийг худалдах, шилжүүлэх, акталж устгах, зориулалтыг өөрчлөх, шинээр олж авах тохиолдол бүрт санал дүгнэлт гаргах.

2.2.4. Зөвлөл нь уг саналыг хүлээн авч, ажлын 10 хоногт багтаан эд хөрөнгийг газар дээр нь нягтлан шалгаж, дүгнэлт гаргаж өмч эзэмшигч байгууллагын удирдлагын

саналын хамт сумын Засаг даргад танилцуулсны үндсэн дээр сумын ИТХ-ын Ажлын алба болон аймгийн Орон нутгийн өмчийн газарт хүргүүлэх.

2.2.6. Хөрөнгө оруулалтаар авсан үндсэн хөрөнгө, хөрөнгө оруулалтаар барилгад хийгдсэн их засварын өртөг, мөн хандив, бэлэг тусламжаар олсон үндсэн хөрөнгийг данс бүртгэлдээ бүртгэсэн байдалд хяналт тавьж аймгийн Орон нутгийн өмчийн газарт мэдээлэх.

2.2.7. Эвдэрсэн, гэмтсэн, чанар байдлаа алдсанаас хэрэгцээнд тохирохгүй болсон, тухайн үеийн зах зээлийн үнийн жишгээс хэт өндөр үнээр авсан, хэт доогуур үнээр борлуулсан үндсэн хөрөнгийг илрүүлж, жагсаалтыг үйлдэн, буруутай этгээдээр хохирлыг арилгуулах, зөрчил гаргасан этгээдэд арга хэмжээ авахыг байгууллагын удирдлагаас шаардах, холбогдох газруудад тухай бүрт нь мэдээлэх.

2.2.8. Данснаас хассан, үндсэн хөрөнгийг борлуулснаас олсон орлогыг зөвхөн үндсэн хөрөнгийг сэргээн засварлах, үндсэн хөрөнгө бэлтгэхэд зарцуулж буйд хяналт тавих.

2.2.9. Орон нутгийн өмчийн түрээсийн орлого, зарцуулалт, түрээсийн байрны ашиглалтанд хяналт тавих.

2.2.10. Байгууллагын дарга, нягтлан бодогч нараас жилийн эцэст аймгийн Орон нутгийн өмчийн газарт ирүүлж буй Үндсэн хөрөнгийн хөдөлгөөний судалгаа болон бусад тайлан, мэдээлэлийн үнэн зөв эсэхэд хяналт тавих.

2.2.11. Зөвлөлийн хурлын шийдвэр болон эрх бүхий байгууллагын шийдвэрээр зөвлөлд хариуцуулсан ажлын хэрэгжилтийг хангах.

2.2.12. Зөвлөлийн үйл ажиллагаанд аймаг, сумын ИТХ, Засаг дарга, аймгийн Орон нутгийн өмчийн газрын өмчийн асуудал хариуцсан мэргэжилтэн хяналт тавьж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, тусламж дэмжлэг үзүүлж ажиллана.

Гурав. ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛ

3.1. Зөвлөл нь улирал тутам нэгээс доошгүй удаа хуралдаж, тухайн жилийн төлөвлөсөн ажлын хэрэгжилт, сум, байгууллагын өмч хөрөнгийн холбогдолтой бүхий л асуудлыг хэлэлцэж зөвлөмж, дүгнэлт гаргах бөгөөд ажлын үр дүнгээ иргэд болон холбогдох байгууллага, хамт олонд мэдээлнэ.

3.2. Өмч хамгаалах зөвлөлийн хурлаас өмч хөрөнгийн эзэмшил, ашиглалтын явцын талаарх асуудлаар зөвлөмж, өмч хөрөнгийг олж авах, ашиглалтаас болон бүртгэлээс хасах хөрөнгийн хөдлөл өөрчлөлтийн талаар дүгнэлт гаргана.

3.3. Зөвлөлийн дарга хурлыг товлож, гишүүдэд зарлана.

3.4. Хурлыг зөвлөлийн дарга удирдах бөгөөд гишүүдийн дийлэнх олонх оролцсон тохиолдолд хүчин төгөлдөр болно. Даргын эзгүйд асуудал хэлэлцүүлж буй гишүүн удирдана.

3.5. Хурлаар хэлэлцэгдэх асуудал дараах зарчмаар боловсруулагдсан байна. Үүнд:

- Тухайн асуудлын үндэслэл
- Тухайн асуудлын танилцуулга
- Дүгнэлт

3.6. Хурлаар асуудал хэлэлцэхдээ дараах дарааллыг баримтална.

3.6.1. Асуудлыг зөвлөлийн дарга танилцуулна.

3.6.2. Хэлэлцэж буй асуудалтай холбогдсон асуулт, хариулт

3.6.3. Зөвлөлийн гишүүдийн санал, дүгнэлт

3.6.4. Хурлын даргаас хэлэлцэж буй асуудлын талаар гаргах дүгнэлтийн төсөл танилцуулах

3.6.5. Дүгнэлтийг санал хурааж батлах

3.7. Хурлын тэмдэглэлийг зөвлөлийн аль нэг гишүүнд байнга хөтлүүлэхээр хариуцуулах ба тэмдэглэлээр үйлдэгдсэн хурлын дүгнэлт нь хуралд оролцсон гишүүдийн олонхийн саналаар шийдвэрлэж, гишүүд гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно. Харин шийдвэрт санал нийлээгүй гишүүн тодорхой тайлбартайгаар гарын үсэг зурна.

3.8. Хүндэтгэн үзэх шалтгаанаар хуралд оролцох боломжгүй болсон гишүүн саналаа бичгээр өгч болно.

3.9. Зөвлөлийн хурлаар хэлэлцэж буй өмчийн эзэмшигч байгууллагын дарга, захирал болон санхүүгийн ажилтан, өмч хариуцсан няравыг заавал оролцуулах ба шаардлагатай тохиолдолд бусад холбогдох ажилтнуудыг оролцуулж болно.

3.10. Өмч эзэмшигч байгууллага өмч хамгаалах зөвлөлийн хурлаас олонхийн саналаар шийдвэрлэсэн зөвлөмж, дүгнэлтийг заавал биелүүлэх үүрэг хүлээнэ.

3.11. Зөвлөлийн гишүүдийн хурлын ирцийг зөвлөлийн дарга бүртгэж, хагас бүтэн жилээр гишүүн бүрээр хуралд оролцсон байдал, гаргасан санал, өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг танилцуулна.

3.12. Зөвлөлийн хурлыг салбар зөвлөл болон өмч эзэмшигч байгууллагын хамт олны төлөөллийг оролцуулан өргөтгөсөн хэлбэрээр хуралдуулж болно.

Дөрөв. ХҮЛЭЭХ ХАРИУЦЛАГА

4.1. Энэ журамд заасан эрхийг хэтрүүлсэн, үндсэн хөрөнгө данснаас хасахтай холбогдсон баримт бичгийг хуурамчаар үйлдсэн, энэ журамд заасан үндэслэлгүй байхад данснаас хасах дүгнэлт, санал гаргасан, аймаг, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн шийдвэрээс өөрөөр захиран зарцуулсан, бусад өмчийн этгээдэд өмч хөрөнгийг өгч завшуулсан, хувьдаа ашиглан шамшигдуулсан буюу эдгээртэй адилтгах бусад үйлдэл, хийсэн гэм буруутай этгээдэд эрх бүхий байгууллага эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр хуулийн байгууллагад шилжүүлнэ.

4.2. Хууль тогтоомж зөрчигчдөд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол Зөрчлийн тухай хууль болон Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 82 дугаар зүйлийн дагуу эрх бүхий албан тушаалтан, ажилтанд хариуцлага тооцно.